



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2015 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улс дахь сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол (ХДХВ/ДОХ)-ын тархалтыг бууруулах, хязгаарлах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий сайд Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/Монгол Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу “Үндэсний хороо”-г дахин байгуулж, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний гурав дахь стратегийг боловсруулж, 2016 оны II улиралд батлах, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээнд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;

3/бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны зардлыг эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судалж шийдвэрлэх;

4/сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг МҮОНРТ, Боловсрол суваг болон бусад радио, телевиз, сонин хэвлэл, нийгмийн сүлжээг ашиглан хүн амын дунд зохион байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

5/жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах;

6/ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт сурагчдад эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох хичээлийг бие даасан хэлбэрээр тусгах;

7/Сүрьеэ, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын болон лабораторийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх сургалтыг зохион байгуулах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, энэ чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх;

8/Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдын зүгээс ажиллагсдаа сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

9/Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, дэн буудал, аялал жуулчлалын болон амралтын газрын үйлчилгээнд хамгаалах хэрэгсэл (бэлгэвч)-ийн хэрэглээг хэвшүүлэх.

3.Байнгын хорооны тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах ажлыг зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай:


1/харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/хүн амын эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон зөвлөгөө өгөх төвд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ